

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Б.Энхмандал

Утас: 70453799, Цахим хаяг: enkhmandal.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ӨМНӨГОВЬ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Б.БАТЦОГ
ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠑ № УВА-᠒᠐᠒᠒/᠓᠒/᠋᠋᠋-᠑᠒᠋-᠑᠒᠑᠒
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөговь сумын Соёлын төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчин хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 5,672.6 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0200200343

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>21,617,327.00</u>	<u>22,198,327.00</u>
33	АВЛАГА	74,245.00	74,245.00
335	Бусад авлага	74,245.00	74,245.00
3351	Байгууллагаас авах авлага	74,245.00	74,245.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21,543,082.00	22,124,082.00
354	Хангамжийн материал	21,543,082.00	22,124,082.00
35410	Бичиг хэргийн материал	257,500.00	257,500.00
35420	Аж ахуйн материал	13,092,982.00	13,673,982.00
35450	Барилгын засварын материал	192,600.00	192,600.00
35470	Бусад хангамжийн материал	8,000,000.00	8,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>698,634,005.42</u>	<u>684,805,679.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	698,634,005.42	684,805,679.80
392	Биет хөрөнгө	681,496,005.42	667,667,679.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	576,459,993.00	585,725,999.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,837,278.07	-31,482,876.87
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,300,118.00	98,000,118.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-67,998,755.30	-75,143,767.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,089,398.70	28,089,398.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,602,150.82	-24,163,871.44
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	68,824,835.00	68,824,835.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,500,000.00	23,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,933,333.09	-16,433,333.05
39217	Ном	10,693,178.00	10,751,178.00
393	Биет бус хөрөнгө	17,138,000.00	17,138,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,138,000.00	17,138,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>720,251,332.42</u>	<u>707,004,006.80</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>72,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	72,000.00
413	Өглөг	00.00	72,000.00
4136	Бусад өглөг	00.00	72,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	72,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>720,251,332.42</u>	<u>706,932,006.80</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	720,251,332.42	706,932,006.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	173,592,747.00	173,592,747.00
51101	Өмч: - төрийн	173,592,747.00	173,592,747.00
512	Хуримтлагдсан үр дүн	424,480,652.02	411,161,326.40
51210	Өмнөх үеийн үр дүн	424,480,652.02	424,480,652.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-13,319,325.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122,177,933.40	122,177,933.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>720,251,332.42</u>	<u>707,004,006.80</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	112,304,976.00	107,180,832.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,452,076.00	4,987,632.44
120	Нийтлэг татварын бус орлого	14,452,076.00	4,987,632.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,452,076.00	4,987,632.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,924.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,430,152.00	4,987,632.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,852,900.00	102,193,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,852,900.00	102,193,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,852,900.00	102,193,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	118,061,992.32	120,500,158.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	118,061,992.32	120,500,158.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,186,344.45	118,735,080.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,369,450.00	59,357,988.00
210101	Үндсэн цалин	54,479,189.00	54,347,067.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,890,261.00	5,010,921.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,535,176.13	7,842,308.84
210201	Тэтгэврийн даатгал	5,119,737.73	5,443,686.40
210202	Тэтгэмжийн даатгал	624,188.73	599,655.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	403,361.98	479,963.70
210204	Ажилгүйдлийн даатгал	152,817.75	119,691.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,235,069.94	1,199,311.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,243,372.00	26,842,085.75
210301	Гэрэл, цахилгаан	745,411.00	710,925.75
210302	Түлш, халаалт	24,497,961.00	26,131,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,285,498.00	747,740.00
210401	Бичиг хэрэг	231,208.00	191,600.00
210402	Тээвэр, шатахуун	495,490.00	258,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	285,000.00	118,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	273,800.00	179,500.00
2105	Нормативт зардал	00.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	923,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	923,000.00
2107	Томилолт, зочны зардал	56,000.00	132,000.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	132,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	326,380.00	216,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236,380.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,070,468.32	22,573,958.06
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,070,468.32	22,573,958.06

Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,875,647.87	1,765,077.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,575,647.87	1,515,077.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,575,647.87	1,515,077.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,757,016.32	-13,319,325.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,757,016.32	-13,319,325.62

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	97,852,900.00	102,193,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,852,900.00	102,193,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,852,900.00	102,193,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,852,900.00	102,193,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	97,852,900.00	102,193,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,852,900.00	102,193,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,977,252.13	100,428,122.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,428,010.00	59,357,987.00
210101	Үндсэн цалин	54,537,749.00	54,347,067.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,890,261.00	5,010,920.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,451,900.13	7,842,309.84
210201	Тэтгэврийн даатгал	5,074,284.73	5,443,686.40
210202	Тэтгэмжийн даатгал	594,434.73	599,655.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	475,520.98	479,963.70
210204	Ажилгүйдлийн даатгал	118,905.75	119,691.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,188,753.94	1,199,312.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,111,764.00	26,842,085.75
210301	Гэрэл, цахилгаан	613,803.00	710,925.75
210302	Түлш, халаалт	24,497,961.00	26,131,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,281,098.00	739,740.00
210401	Бичиг хэрэг	231,208.00	191,600.00
210402	Тээвэр, шатахуун	495,490.00	258,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	321,000.00	118,000.00
210404	Ном, хэвлэл	59,100.00	38,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	174,300.00	133,500.00
2105	Нормативт зардал	500,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	822,100.00	5,073,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000.00	4,150,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	99,500.00	00.00
210604	Урсгал засвар	492,600.00	923,000.00
2107	Томилот, зочны зардал	56,000.00	132,000.00
210702	Дотоод албан томилот	56,000.00	132,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	326,380.00	341,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236,380.00	125,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,875,647.87	1,765,077.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,575,647.87	1,515,077.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,575,647.87	1,515,077.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	156,454,747.00	14,414,385.02	51,578,530.49	00.00	222,447,662.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,454,747.00	14,414,385.02	51,578,530.49	00.00	222,447,662.51
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	17,138,000.00	00.00	-42,494,344.78	00.00	-25,356,344.78
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,592,747.00	122,177,933.40	424,480,652.02	00.00	720,251,332.42
D01	2021 оны 12-р сарын 01-нээрх үлдэгдэл	173,592,747.00	122,177,933.40	424,480,652.02	00.00	720,251,332.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,592,747.00	122,177,933.40	424,480,652.02	00.00	720,251,332.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,319,325.62	00.00	-13,319,325.62
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,592,747.00	122,177,933.40	411,161,326.40	00.00	706,932,006.80

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,943,200.00	100,678,122.59	3,265,077.41	96.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,943,200.00	100,678,122.59	3,265,077.41	96.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,443,200.00	100,428,122.59	3,015,077.41	97.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,398,200.00	59,357,987.00	40,213.00	99.93
210101	Үндсэн цалин	54,358,200.00	54,347,067.00	11,133.00	99.98
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,010,920.00	29,080.00	99.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,018,800.00	7,842,309.84	176,490.16	97.80
210201	Тэтгэврийн даатгал	5,642,800.00	5,443,686.40	199,113.60	96.47
210202	Тэтгэмжийн даатгал	594,000.00	599,655.90	-5,655.90	100.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	475,120.00	479,963.70	-4,843.70	101.02
210204	Ажилгүйдлийн даатгал	118,880.00	119,691.20	-811.20	100.68
210205	Эрүүл мэндийн даатгал	1,188,000.00	1,199,312.64	-11,312.64	100.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,955,600.00	26,842,085.75	1,113,514.25	96.02
210301	Гэрэл, цахилгаан	1,823,700.00	710,925.75	1,112,774.25	38.98
210302	Түлш, халаалт	26,131,900.00	26,131,160.00	740.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	931,000.00	739,740.00	191,260.00	79.46
210401	Бичиг хэрэг	204,100.00	191,600.00	12,500.00	93.88
210402	Тээвэр, шатахуун	330,900.00	258,640.00	72,260.00	78.16
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	118,000.00	82,200.00	58.94
210404	Ном, хэвлэл	50,000.00	38,000.00	12,000.00	76.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	133,500.00	12,300.00	91.56
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,166,100.00	5,073,000.00	93,100.00	98.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,159,300.00	4,150,000.00	9,300.00	99.78
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	00.00	83,300.00	0.00
210604	Урсгал засвар	923,500.00	923,000.00	500.00	99.95
2107	Томилолт, зочны зардал	133,500.00	132,000.00	1,500.00	98.88
210702	Дотоод албан томилолт	133,500.00	132,000.00	1,500.00	98.88

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,000.00	341,000.00	1,399,000.00	19.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,524,000.00	125,000.00	1,399,000.00	8.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500000.00	250,000.00	250,000.00	50.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	250,000.00	250,000.00	50.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	250,000.00	250,000.00	50.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	103,943,200.00	102,193,200.00	1,750,000.00	98.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	103,943,200.00	102,193,200.00	1,750,000.00	98.3
132001	Орон нутгийн төсвөөс	103,943,200.00	102,193,200.00	1,750,000.00	98.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	06.00	06.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	06.00	06.00	0.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	04.00	04.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	01.00	01.00	0.00	100.00
650010	Гэрээт ажилтан	01.00	01.00	0.00	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхмандал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өмнөговь сумын Соёлын төв нь “Соёлын үнэт зүйлийг өвлөн хамгаалж түгээн дэлгэрүүлж, бүх нийтэд соёл урлагийн боловсролыг эзэмшүүлж авьяас билгийг нээн хөгжүүлж орон нутгийн болон аймаг бүсийн хэмжээнд соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэж соёлын өв уламжлалыг хүүхэд залуучуудад сурталчлан таниулж өвлүүлэн үлдээхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 944.4 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 120,500.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 1,205.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 964.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,248.0 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	74.2	74.2	0.0
Бараа материал	21,543.0	22,124.0	581.0
Үндсэн хөрөнгө	698,634.0	684,805.6	-13,829.0
Нийт хөрөнгө	720,251.3	707,004.0	-13,248 .0

Өр төлбөр	00.0	72.0	72.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	720,251.3	706,932.0	-13,320.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	720,251.3	707,004.0	-13,248.0

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22,124.0 мянган төгрөг болж 581.0 мянган төгрөгөөр өссөн нь 1,783.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, 191.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 684,805.6 мянган төгрөг болж 13,828.4 мянган төгрөгөөр буурсан нь 22,573.9 мянган төгрөгийн тайлант оны элэгдэл, хорогдлын зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс нь 9,266.0 мянган төгрөгийн Увс аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын А/160 тогтоолоор шилжүүлж авсан цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа, сагсан бөмбөгийн тайлбай, 3,700.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж мөн 58.0 мянган төгрөгийн ном авснаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 706,932.0 мянган төгрөг болж 13,319.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 5,124.1 мянган төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө шилжүүлж авсан, бараа материалын зарцуулалт тайлант онд бага байсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 2,438.1 мянган төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна. Энэ нь түлш халаалт, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлууд байна. Энэ нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардал өссөнтэй холбоотой байна.

Тайлант онд байгууллагад төлөх өр үүссэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өмнөговь сумын Соёлын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 99,075.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих, 2,042.5 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос санхүүжих, нийт 101,117.6 мянган төгрөг, нийт зарлагыг 101,117.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,825.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 103,943.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх төсвийн хэмнэлтийг нэмж олгосонтой холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 103,943.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 103,943.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 102,193.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 102,193.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 100,678.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 100,678.1 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан.

Өмнөговь сумын Соёлын төвийн хувьд тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 98, хугацаа хороож

53 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тухай зөвлөмж авсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу ажил гүйлгээг Нягтлан бодох бүртгэлд тусгаж байгаа асуудлыг анхаарах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 113,784.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 34,878.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 73,233.2 мянган төгрөгийн албан шаардлага, 5,672.6 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин 34,878.8 мянган төгрөгийн урсгал зардлыг шууд зардалд бүртгэж тайлагнасныг залрууллаа.

4.2 Албан шаардлага

Аудитаар шилэн дансны сайтад 53 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 73,233.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага өглөө.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

1.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчин хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 5,672.6 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

1.1. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	113,784.6	1	34,878.8			1	73,233.2	1	5,672.6
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	3	113,784.6	1	34,878.8			1	73,233.2	1	5,672.6

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР /Б.ЭНХМАНДАЛ/

2022 оны 02 сарын 21-ний өдөр